

ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ “ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
 ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
 /2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар/

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	Арга хэмжээний дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн эх үүсвэр)		Хэрэгжилтийн хувь
						2023 он		
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
1	2	3	4	5	6	7	8	9
НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО								
1.1. “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.								
1.1.5.Экспорт ыг дэмжих санхүүгийн шийдлүүдийг боловсруулж, экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.	1	Экспортыг дэмжих санхүүгийн шийдлүүдийг боловсруулж, экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.	2020 - 2024	Сангийн яам	-	Экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлнэ.	1.Ашигт малтмалын экспортод тавих гаалийн хяналт шалгалтыг сайжруулах, хилээр нэвтрүүлэх цаг хугацааг багасгах, экспортыг дэмжих зорилгоор ашигт малтмалд гүний гаалийн хяналтад ачилт хийлгэх байдлаар ачилтын үйл явцыг хяналтын камераар хянаж, гаалийн бүрдүүлэлт хийлгээд, гаалийн итгэмжлэл авсан тээвэрлэгчийн битүүмжлэлтэй тээврийн хэрэгслээр хилийн гаалийн хяналтад хүргүүлдэг. Автозамын хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн программыг бүрэн нэвтрүүлсэн. Үүний үр дүнд тээврийн хэрэгсэл эзэмшигч нар хилийн боомтоор нэвтрэх бүртгэлийн мэдээллийг CEPS системд өөрсдөө нөхөж	100

						<p>бичээд, гаалийн байгууллагын CAIS системд илгээснээр хил дээр дараалалд зогсох шаардлагагүй болсон.</p> <p>2.Автозамын хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг, ухаалаг гарцын тоног төхөөрөмжөөр бүртгэх бүртгэлийг Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулан үе шаттайгаар нэвтрүүлсэн. Уурхайгаас ачигдсан экспортын барааг хилийн боомт дээр жолоочгүй тээврийн хэрэгсэл /AGV/-д шилжүүлэн ачиж, хилээр гаргах тээвэрлэлтийг Шивээхүрэн боомтоор 2023 оны 03 дугаар сарын 01, Гашуунсухайт боомтоор 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлүүлсэн.</p> <p>БНХАУ-тай хиллэдэг автозамын хилийн боомтуудаар 2023 оны 1 дүгээр сард өдөрт дунджаар экспортын эрдэс бүтээгдэхүүн ачсан 1307 орчим тээврийн хэрэгслийг хилээр нэвтрүүлж байсан бол 12 дугаар сард 2492 орчим болж нэмэгдсэн.</p> <p>Гашуунсухайт болон Ганцмод боомтын дунд хилийн 0 цэгт 2022 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 20 /AGV/ автомат удирдлагатай тээврийн хэрэгслээр чингэлэг солилцож, нүүрс гаргах ажлыг туршилтаар эхлүүлсэн. Энэ тоог нэмэгдүүлсээр өнөөдрийн байдлаар 160 автомат удирдлагатай тээврийн хэрэгслээр өдөрт 320 чингэлэг нүүрс гаргаж байна.</p> <p>ГЕГ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/549 дүгээр тушаалаар Гашуунсухайт боомтын ойролцоох 56 га талбайг /AGV/ автомат удирдлагатай тээврийн хэрэгслээр чингэлэг солилцох</p>
--	--	--	--	--	--	---

							<p>гаалийн хяналтын бүсээр тогтоосон. Мөн Шивээхүрэн боомтоор эрдэс бүтээгдэхүүн экспортлогч компаниуд хамтран /AGV/ автомат удирдлагатай тээврийн хэрэгслээр чингэлэгт ачигдсан нүүрсийг хилээр гаргаж байна.</p> <p>2.Гаалийн хяналтад хамрагдсан экспортын зарим барааны тоо /2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар/:</p> <ul style="list-style-type: none"> - Рапс 73530,4 тн, - Дэрэвгэр жиргэрүү 61,9 тн, - Самрын боловсруулсан идээ 8440,9 тн, - Хивэг 22051 тн, - Адууны мах 30257 тн, - Дулааны аргаар боловсруулсан үхэр, хонь, ямааны мах 25341 тн, - Хонь, ямааны мах 9076,8 тн, - Малын дайвар бүтээгдэхүүн 966,1 тн <p>-Нядалгааны зориулалттай хонь, ямаа 111129 толгой.</p>	
--	--	--	--	--	--	--	--	--

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.1.Санхүү, эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах бодлого хэрэгжүүлнэ.

3.1.10.Гадаад худалдааг дэмжсэн гаалийн үйлчилгээг хялбаршуулж, иргэдийг хууль бус, хуурамч бараанаас сэргийлэх, байгалийн баялгаас татварыг бүрэн	1	Барааны борлуулалтын шат дамжлага бүрийг бараа бүртгэлийн нэгдсэн системээр дамжуулан бүртгэж иргэд гар утасны "и-баримт" аппликейшн ашиглан тамхи, согтууруулах	2020 - 2024	Сангийн яам Хамтрагч Гаалийн ерөнхий газар	-	Бүх төрлийн хүнсний барааг Бараа бүтээгдэхүүний нэгдсэн системээр дамжуулан бүртгэсэн байна.	“Хүнсний хувьсгал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, мөрдөн мөшгих тогтолцоог сайжруулах хүрээнд “Бүх төрлийн хүнсний барааг Бараа бүтээгдэхүүний нэгдсэн системээр дамжуулан бүртгэх цахим санг бий болгох зорилгоор импортоор анх удаа орж ирсэн хүнсний бараа, түргэн гэмтэх хүнсний барааны лабораторийн шинжилгээ, илрүүлсэн зөрчлийн бүртгэлээр дамжуулан үүсгэх зорилгоор хилийн удирдлагын цахим системд “Барааны сан”-г бар кодоор үүсгэх 23 талбарыг хөгжүүлж, ажиллагаанд нэвтрүүлэх бэлэн байдлыг хангалаа.	100
--	---	--	-------------------	--	---	--	---	-----

<p>хураахад чиглэсэн гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.</p>		<p>ундаа зэрэг онцгой албан татвартай бүх төрлийн бараа, эмийн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар зэрэгт хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.</p>					<p>CAPS.GAALI.MN цахим сайт дээр Засгийн газраас гаргасан журмын дагуу “Импортын эрсдэлийн үнэлгээ хийсэн аж ахуйн нэгжийн жагсаалт”-ыг импортын мэдэгдлийн “Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүн импортлох мэдэгдэл” өгөгдлийн сан дээр нэмж тус жагсаалтаас сонгох боломжтой болгосон.</p> <p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/372 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг мах, махан бүтээгдэхүүний экспортын үйл ажиллагаанд хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн экспортын нэг цонхны системийг бий болгох зорилгоор Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүн экспортлох үйл ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газар, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Хөдөө аж ахуйн бирж зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог хангаж, өөрсдийн хэрэглэдэг мэдээллийн системүүдийг хөдөө аж ахуйн экспортын нэг цонхны системд холбож, салбар дундын https://export.mofa.gov.mn/publicpage цахим системийг бий болгосон.</p> <p>Уг цахим систем 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллаж, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар системд 71 компани өөрийн бүртгэлээ үүсгэн, цахимаар экспортын гэрчилгээг авч жигдэрсэн байна.</p>	
--	--	--	--	--	--	--	--	--

							Цаашид ХХААХҮЯ-ны ажлын чиг үүрэгт хамаарах үндсэн ажил болох “Монгол Улсын хүнсний бүтээгдэхүүний бүртгэлийн нэгдсэн цахим систем”-д гаалийн байгууллагаас импорт, экспортын хүнсний барааны мэдээг холбоход тоног төхөөрөмж, серверийн хувьд боломжтой.	
3.1.17.Чөлөөт бүсүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, экспорт болон дотоодын зах зээлд чиглэсэн худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллана.	3	“Алтанбулаг” чөлөөт бүсийг Гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбоно.	2022 - 2024	Хамтрагч Сангийн яам, Гаалийн ерөнхий газар	-	Хөрөнгө оруулагч нар Гаалийн нэгдсэн сүлжээнд холбогдсоноор чөлөөт бүсэд нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн нэвтрэх чадвар 2 дахин нэмэгдэж, төрийн хяналт шалгалт сайжирна.	1.Гаалийн автоматжуулсан системийг шинэчлэх ажлын хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа дэлгүүрүүд, мөн гаалийн нутаг дэвсгэрийн гүнд болон хилийн боомтуудад татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн программд тавигдах техникийн нөхцөл, шаардлагуудыг Гаалийн ерөнхий газраас 2022 оны 9, 10 дугаар саруудад 02-1/2831, 02-1/2526 албан бичгүүдээр харьяа гаалийн газар, хороодын дарга нарт хүргүүлсэн. Дээрх ажлын хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлдэг дэлгүүрүүд өөрсдийн хэрэглэж байгаа программд хөгжүүлэлт хийж, гаалийн мэдээллийн системд холбуулах хүсэлтэй байгаа талаарх судалгааг Захирагчийн ажлын албанаас ирүүлсэн. Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба болон тус чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж буй дэлгүүрийн программ хариуцаж буй Мэдээллийн технологийн компанийн төлөөлөлтэй 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр уулзалт хийж, программын мэдээлэл солилцох техникийн тодорхойлолт болон зааврыг өгсөн. Үүний үр дүнд “Алтанбулаг” чөлөөт бүсийн үйл ажиллагаа явуулж буй нийт 31 аж ахуйн нэгжүүдээс 9 дэлгүүрийн хөгжүүлэлт нь дуусаж, төстийн орчинд туршсан. Үйл	70

						<p>ажиллагаанд нэвтрүүлэхэд бэлэн болсон боловч тухайн дэлгүүрүүд ажиллахгүй байгаа учир бүрэн нэвтрээгүй. Аж ахуйн нэгжүүд API холболтын зааварчилгаа авсан.</p> <p>2.Гаалийн ерөнхий газар газар болон Сэлэнгэ аймаг дахь гаалийн газраас Алтанбулаг чөлөөт бүсийн ажлын алба, Алтанбулаг чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд 2019 онд 27, 2020 онд 6, 2021 онд 14 буюу нийт 47 удаагийн албан бичгээр теле хяналтын камер тавих, гаалийн байгууллагатай нэгдсэн системд холбогдох, хуульд заасан шаардлагыг мөрдүүлэх зэрэг асуудлаар хандсан.</p> <p>Алтанбулаг чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас:</p> <p>-Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний “Засаглалын бодлого”-ын “Алтанбулаг чөлөөт бүсийг гаалийн теле хяналтын нэгдсэн системд холбох” хэсэгт шилэн кабелийн зардлыг тусгаж оруулсан боловч төсөвт суугдаагүй;</p> <p>-Чөлөөт бүсийн дэд бүтцийн барилга байгууламжийн ажлын улсын төсвийн хөрөнгө оруулалт зогсож, сүүлийн 8 жилд хөрөнгө оруулалтын зардал огт тавигдаагүй. 2016 оноос эхлэн төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлсэн.</p> <p>-Өнөөдрийн байдлаар Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанаас 2022 оны төсвийн төсөөлөлд саналаа хүргүүлсэн боловч батлагдаагүй учраас 2023 онд “genetic system”-ийн үнийн саналыг дахин судалж, шинэчлэн хүргүүлсэн болно гэж хариу ирүүлсээр байна.</p>	
--	--	--	--	--	--	---	--

							<p>3. Алтанбулаг чөлөөт бүсэд зорчигчийг орох үед регистрийн дугаараар нь ХУР-системээс мэдээллийг татаж шалган, бар кодтой хуудас хэвлэж өгч, тухайн зорчигч бар кодтой хуудсаа үндэслэн худалдан авалт хийж байгаа бөгөөд барааны худалдан авалт нь 3 сая төгрөгөөс давсан тохиолдолд анхааруулга өгч байна.</p> <p>Бар кодтой хуудсыг дахин ашиглахгүй болгосон, мөн бусдын иргэний үнэмлэхийг ашиглан худалдан авалт хийх боломжгүй болгосон.</p> <p>Тайлбар: Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч, өөрсдөөс хамаарах зохион байгуулалтын арга хэмжээ авагдсан.</p>	
3.1.18.Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, хөрш орнуудын хилийн боомтуудын жишигт хүргэнэ. Хилийн заставуудын барилга, объектуудыг шинэчилж чанарыг сайжруулна.	1	Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж сайжруулна.	2021 - 2024	Сангийн яам Хамтрагч Гаалийн ерөнхий газар	-	1.Ханги, Булган, Хавирга боомтын бүтээн байгуулалт, гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийг суурилуулж иж бүрэн сайжруулж, хилээр нэвтэрч буй уул уурхай, эрдэс бүтээгдэхүүнээс дээж авч шинжлэн, татварыг бүрэн ногдуулах нөхцөл бүрдсэн байна.	<p>Хавирга боомтын өргөтгөл шинэчлэлийн ажлын техник эдийн засгийн үндэслэл болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил бүрэн дууссан.</p> <p>Булган боомтын өргөтгөл шинэчлэлийн ажлын техник эдийн засгийн үндэслэл болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил 92 хувийн, Ханги боомтын өргөтгөл шинэчлэлийн ажлын техник эдийн засгийн үндэслэл болон нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил 96 хувийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>Булган, Хавирга боомтуудын өргөтгөл шинэчлэлийн ажлыг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр гүйцэтгэх шийдвэр гарсан.</p> <p>Ханги боомтод 2024 онд багтаан ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжийг суурилуулахаар болж, байршлыг урьдчилан тогтоосон.</p>	60

Тайлбар: Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч, өөрсдөөс хамаарах зохион байгуулалтын арга хэмжээ авагдсан

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.3. Амар тайван, аюулгүй нийгэм. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.

<p>4.3.13.Иргэдийн эрүүл бүтээгдэхүүн хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтүүдийг өндөр нарийвчлалтай тодорхойлж, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрсдэлд суурилсан хяналтаар чанд мөрдүүлнэ.</p>	<p>2</p>	<p>Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох чадварыг нэмэгдүүлж Хүнсний аюулгүй байдлыг хангуулна.</p>	<p>2020-2024</p>	<p>Мэргэжлийн хяналтын ерөнхий газар</p>		<p>Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй үзүүлэлтийг тодорхойлох чадвар бүхий лабораторийн багаж, тоног төхөөрөмжөөр хангасан байна.</p>	<p>Хилийн мэргэжлийн хяналтын чиг үүрэг гаалийн байгууллагад нэгдсэнтэй холбоотойгоор гаалийн байгууллага дараах ажлуудыг зохион байгуулсан.Үүнд: 1.Хорио цээрийн хяналт хийх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гаалийн хяналт, шалгалтын үйл ажиллагаатай уялдуулах зорилгоор Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/315 дугаар тушаалаар “Бараанаас дээж сорьц авах, магадлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах журам”-ыг боловсруулж, батлуулсан. 2.Замын-Үүд болон Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомт дахь гаалийн салбар лабораторийн хилийн мэргэжлийн хяналтын лабораторийг чадавжуулах хүрээнд RIBS төслөөр 1,249,268\$ өртөг бүхий шинжилгээний тоног төхөөрөмж, зөөврийн багаж хэрэгсэл, урвалж бодис, шил сав, лабораторийн тавилга, хэрэгслийг нийлүүлснийг санхүүгийн баримтаар гаалийн байгууллага хүлээн авсан. Боомтын сэргэлтийн хүрээнд тус салбар лабораториудын барилга баригдаж, ашиглалтад орсон бөгөөд дээрх боомтууд дээр хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуй, аюулгүй үзүүлэлтүүд, ургамал хорио цээрийн иж бүрэн, нарийвчилсан шинжилгээ хийж байна.</p>	<p>100</p>
---	----------	--	------------------	--	--	---	---	------------

						<p>3.2022 онд Гаалийн төв лаборатори, Дорнод аймаг дахь гаалийн газрын Баянхошуу, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын Цагааннуур, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар, Увс аймаг дахь гаалийн газрын Боршоо боомтын салбар лабораториудад хүнсний шинжилгээний чиглэлээр нийт 133 тоног төхөөрөмжийг захиалан, хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуй, аюулгүй үзүүлэлтүүд, ургамал хорио цээрийн шинжилгээ хийж байна. 2023 онд Гаалийн төв лаборатори, Увс аймаг дахь гаалийн газрын Цагааннуур, Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар болон Гашуунсухайт дахь гаалийн газрын салбар лабораториудад хүнсний хорио цээр, у эрүүл ахуйн чиглэлээр нийт 33 төхөөрөмжийг захиалан, нийлүүлэгдээд байна.</p> <p>Үүний үр дүнд Гаалийн төв лаборатори, Замын-Үүд дэх гаалийн газар болон Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын салбар лабораториудад хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуй, аюулгүй үзүүлэлтүүд, ургамал хорио цээрийн иж бүрэн, нарийвчилсан шинжилгээ, бусад салбар лабораториуд нь хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуй, аюулгүй үзүүлэлтүүд, ургамал хорио цээрийн анхан шатны шинжилгээ хийж байна.</p> <p>4.2023 онд гаалийн хилээр нэвтэрсэн 223690,7 тн, 118.981.558 ширхэг, 700 хайрцаг бараанаас 16096 удаа 50916,6 кг, 14597 ширхэг, 107,7 л барааг хорио цээрийн хяналтын зорилгоор лабораторийн шинжилгээнд хамруулахад 87842 үзүүлэлтээр шаардлага хангаж, 206 үзүүлэлтээр шаардлага хангаагүй байна.</p>	
--	--	--	--	--	--	---	--

							Шаардлага хангаагүй барааны 64 сорьц нь ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд дотоод хорио цээртэй хог ургамал, шавж үхсэн хэлбэрээр, гадаад хорио цээртэй хөнөөлт шавжийн сэг зэм илэрсэн тул устгах, буцаах арга хэмжээг авч, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангасан.	
4.5.Тогтвортой, нэгдмэл гадаад бодлого. Монгол улс уламжлалт гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагаагаа тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн гадаад таатай орчныг улам бэхжүүлнэ.								
4.5.2.Эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.	3	Худалдаанд тулгарч байгаа хүндрэлийг багасгах зорилгоор гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан байгуулж, гадаад худалдаатай холбоотой бүх мэдээллийг түргэн шуурхай, нэг цэгээс авах боломжийг бүрдүүлнэ. Цаасгүй худалдаа, цахим худалдааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох	2021-2024	Гадаад харилцааны яам Хамтрагч Гаалийн ерөнхий газар		Бүрдүүлэлтийн нэгдсэн төвийг ашиглалтад оруулсан байна.	“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гаалийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа цахимжуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгж, зуучлагч нартай нүүр тулсан харилцаанаас зайлсхийж, гаалийн бүрдүүлэлтийг цахим хэлбэрт шилжүүлэн “Бүрдүүлэлтийн нэгдсэн төв”-д үйл ажиллагааг төвлөрүүлэх ажлыг туршилтын журмаар эхлүүлсэн. “Бүрдүүлэлтийн нэгдсэн төв”-ийг туршилтын журмаар байгуулах тухай танилцуулга, материалыг Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/253 дугаар тушаалаар батлуулсан. Уг тушаалаар “Бүрдүүлэлтийн нэгдсэн төв”-ийн үйл ажиллагааг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, төлөвлөгөө батлагдаж, дараах ажлуудыг хийсэн. Үүнд: -2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/292 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Цахим хэлбэрээр мэдүүлэхэд гаалийн мэдүүлэг нөхөн бичих түр заавар”-ыг, 2 дугаар хавсралтаар “Цахим хэлбэрээр	100

		чиглэлээр ажиллана.					<p>мэдүүлэхэд гаалийн мэдүүлэг шалгах түр заавар"-ыг тус тус баталсан.</p> <p>-“Бүрдүүлэлтийн нэгдсэн төв”-ийн үйл ажиллагааг Улаанбаатар хот дахь гаалийн газарт нэвтрүүлэх ажлыг туршилтын хугацаанд 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлсэн. “Бүрдүүлэлтийн нэгдсэн төв”-д гаалийн байгууллагад мэдүүлсэн барааны гаалийн бүрдүүлэлтийг бичиг баримтын шатанд нь цахимаар хийж эхэлсэн. Өөрөөр хэлбэл төвлөрсөн байдлаар нэг цэгт цахимаар хийж, гадаад худалдаа эрхлэгч бичиг баримтаа шалгуулахаар заавал гаалийн байгууллагад ирж нүүр тулсан харилцаа үүсгэхгүйгээр гаалийн цахим үйлчилгээ авах юм. Ингэхдээ мэдүүлэгч гаалийн байгууллагад бараа, бүтээгдэхүүнээ зайнаас мэдүүлж болох бөгөөд гадаад худалдааны бичиг баримтыг гаалийн мэдүүлэгт цахимаар файлаар хавсаргаж байна.</p> <p>-“Бүрдүүлэлтийн нэгдсэн төв”-д Улаанбаатар хот дахь гаалийн газрын Гаалийн хяналтын бүсүүдэд хийгдэж байгаа гаалийн бичиг баримтын бүрдүүлэлтийг үе шаттайгаар нэгтгэж, оруулсан.</p> <p>2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс нийт гаалийн газар, хороод “Бүрдүүлэлтийн нэгдсэн төв”-д бүрэн хамрагдсан.</p>
Дундаж үнэлгээ: 88.33 хувь							

Гаалийн ерөнхий газрын 2023 оны “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” 2021-2024 онд хэрэгжих бөгөөд 2023 онд гүйцэтгэсэн ажлын дундаж үнэлгээ **88.33** хувьтай байна. Цаашид 2024 онуудад хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.